



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/08

Цагаан-Уул сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2025 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Хүүхдийн хөгжилийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нууц товчоонд нэвтрэхүй нэвтрүүлэг бэлтгэх ажлын 7.737.000 (Долоон сая долоон зуун гучин долоон мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч: Н.Алтанбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүн: Н.Сандагсүрэн (Ерөнхий боловсролын сургуулийн номын санч)

Нарийн бичгийн дарга: Ч.Эрдэнэчулуун (Хууль эрх зүйн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Алтанбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2025/